

Геополитикийн өөрчлөлт: Зүүн хойд Азийн бүс нутгийн аюулгүй байдлын сорилтууд ба Монгол Улс

Загдсүрэнгийн Болдбаатар

Доктор (Sc.D), профессор, судлаач, z.boldbaatar.postgrad@gmail.com
Монгол Улс, Улаанбаатар, Батлан хамгаалахын эрдэм шинжилгээний хүрээлэн

Хураангуй

Энэхүү өгүүлэл нь олон улсын тогтолцооны өөрчлөлт болон түүний Зүүн хойд Ази, Монгол Улсын аюулгүй байдлын орчинд үзүүлж буй нөлөөг судлав. Судалгаагаар “хүйтэн дайн”-ы дараах нэг туйлт тогтолцооноос их гүрнүүдийн өрсөлдөөн эрчимжсэн, тэгш бус олон туйлт тогтолцоо руу шилжиж буй үйл явцыг шинжилсэн болно. Неореализм, довтолгооны реализм, геополитикийн онол, бүс нутгийн аюулгүй байдлын цогцолборын онол (Regional Security Complex Theory – RSCT)-ын онолын хүрээнд АНУ–БНХАУ-ын стратегийн өрсөлдөөн, Орос–Украины дайны үр дагавар, Зүүн хойд Ази (ЗХА)-ийн аюулгүй байдлын орчны хувьсал, мөн Дэлхийн Өмнөдийн орнуудын өсөн нэмэгдэж буй нөлөөлөл зэрэг геополитикийн гол өөрчлөлтүүдийг авч үзэв.

Өөрчлөгдөж буй энэхүү стратегийн орчинд Монгол Улсын гадаад бодлого, аюулгүй байдлын сорилтуудыг стратегийн бие даасан байдал болон гуравдагч хөршийн бодлогын хүрээнд үнэлэв. Судалгааны үр дүнд Монгол Улс их гүрнүүдийн өрсөлдөөн эрчимжиж буй нөхцөлд тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдлаа хадгалахын тулд олон тулгуурт, тэнцвэржүүлсэн хамтын ажиллагааны бодлогоо бэхжүүлэх, эдийн засаг болон технологийн түншлэлээ төрөлжүүлэх, кибер болон эдийн засгийн сөрөн тэсвэрлэх чадавхаа нэмэгдүүлэх, бүс нутгийн яриа хэлэлцээний институцилсэн механизмуудыг хөгжүүлэх шаардлагатай гэж үзэв.

Өгүүллийн төгсгөлд тэгш бус олон туйлт тогтолцоо бүрэлдэн тогтож буй өнөөгийн нөхцөлд Монгол Улс үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалаа шинэчлэн хөгжүүлж, геополитик, эдийн засаг, технологи, кибер орчны сорилтуудыг хамарсан уламжлалт болон уламжлалт бус аюулгүй байдлын хэмжүүрүүдийг нэгдмэл байдлаар тусгах шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрсэн.

Түлхүүр үгс: Тэгш бус олон туйлт тогтолцоо их гүрнүүдийн өрсөлдөөн, геоэдийн засаг, гуравдагч хөршийн бодлого, гибрид заналхийлэл, дижитал бүрэн эрхт байдал

Оршил

XXI зууны гурав дахь арван жил бол хүн төрөлхтний түүхэнд геополитикийн хувирал хамгийн эрчимтэй өрнөж буй үе юм. Зөвлөлт Холбоот Улс 1991 онд задран

унаснаар Фрэнсис Фукуямагийн дэвшүүлсэн “Түүхийн төгсгөл” онолын дагуу либерал ардчилал, чөлөөт зах зээлд суурилсан нэг тулгуурт дэлхийн дэг журам урт хугацаанд давамгайлна гэж үзэж байсан боловч өнөөдөр энэхүү төсөөлөл бодит байдалтай нийцэхээ больж байна (Fukuyama F., 1992). Либерал олон улсын дэг журам институцийн болон бүтцийн гүнзгий хямралд орж, эрх мэдлийн төвлөрөл өрнөөс дорно, умардаас өмнөд рүү шилжих үйл явц эрчимжиж байна. Энэхүү шилжилт нь бүс нутгийн болон дэлхийн хэмжээний хүчний тэнцвэрийн төлөөх өрсөлдөөн, зэвсэгт мөргөлдөөн, эдийн засгийн сөргөлдөөнөөр илэрч байна. Нэгэнт тогтсон дүрэмд суурилсан олон улсын систем нь шинээр хүчирхэгжиж буй гүрнүүдийн ашиг сонирхлыг бүрэн хангаж чадахгүй болсон тул дэлхийн улс төрийн систем шинэ тэнцвэрийн эрэлд шилжиж байна.

Орчин үеийн геополитикийн өөрчлөлтийг шинжлэхэд олон улсын харилцааны неореализм буюу бүтцийн реализмын онол тайлбарлах өндөр чадамжаа хадгалсан хэвээр байна. Кеннет Уолтцын үзсэнээр олон улсын системийн анарх бүтэц нь улс орнуудыг аюулгүй байдлаа хангахын тулд хүчний тэнцвэрийн бодлого хэрэгжүүлэхэд хүргэдэг. Энэ үзэл санааг Жон Миршаймер цааш хөгжүүлж, улс орнууд зөвхөн оршин тогтнох бус, бүс нутагтаа давамгайлахын төлөө эрх мэдлээ тасралтгүй нэмэгдүүлэхийг эрмэлздэг хэмээн тайлбарласан байдаг (Mearsheimer J. J., 2001). Мөн Грэхэм Аллисоны томьёолсон “Тукидидын хавх” онол хүчирхэгжиж буй гүрэн болон ноёрхогч гүрний хоорондын өрсөлдөөн мөргөлдөөнд хүрэх эрсдэл өндөр байдгийг онцолдог. Өнөөгийн АНУ-БНХАУ-ын стратегийн өрсөлдөөн нь энэхүү онолын бодит жишээ болж байна (Allison G. T., 2017).

Геополитикийн орчин үеийн өөрчлөлтийг зөвхөн цэргийн хүчин зүйлээр тайлбарлах боломжгүй. Хэлфорд Маккиндерийн “Хартленд”-ын онол болон Николас Спикманы “Римленд”-ын онол нь өнөөдөр ч геостратегийн ач холбогдлоо хадгалсан хэвээр байна. Евроазийн эх газрын дотоод бүс болон захын бүсүүдийг хянах өрсөлдөөн нь орчин үед хуурай замын тээвэр, эрчим хүч, дижитал дэд бүтэц, сансрын технологи, нийлүүлэлтийн сүлжээний хяналтын хэлбэрээр үргэлжилж байна (Mackinder H. J., 1904) (Spykman N. J., 1944).

Орчин үеийн геополитикийн хамгийн чухал тэнхлэг нь Вашингтон болон Бээжингийн хооронд өрнөж буй системийн шинжтэй өрсөлдөөн юм. Энэ нь зөвхөн худалдааны алдагдал эсвэл тарифын асуудал бус, харин XXI зууны олон улсын дэг журмын дүрэм, хэм хэмжээг хэн тодорхойлох вэ гэсэн стратегийн асуудал болж хувирсан. АНУ болон БНХАУ-ын хооронд эдийн засгийн “decoupling” болон “de-risking” бодлого сүүлийн жилүүдэд эрчимжиж, нийлүүлэлтийн сүлжээ, технологийн үйлдвэрлэл, хөрөнгө оруулалтын урсгалыг дахин зохион байгуулах үйл явц өрнөж байна (Mearsheimer J. J., 2018) (Friedberg A. L., 2011). Ялангуяа өндөр технологийн салбар дахь өрсөлдөөн улам ширүүсэж байна. АНУ хагас дамжуулагч, хиймэл оюун, квант тооцоолол зэрэг стратегийн технологийн экспортод хязгаарлалт тогтоож, БНХАУ-ын технологийн өсөлтийг сааруулах

бодлого хэрэгжүүлж байна. Үүний хариуд БНХАУ технологийн бие даасан байдлаа нэмэгдүүлэх, үндэсний инновацын чадавхаа өргөжүүлэх бодлогыг эрчимтэй хэрэгжүүлж байна (Johnston A. I., 2003).

Судалгааны онол, арга зүйн үндэс

Энэ судалгаанд олон улсын харилцааны неореализм, довтолгооны реализм, бүс нутгийн аюулгүй байдлын комплексын онолуудыг онолын үндэс болгон ашиглав. Судалгаанд чанарын шинжилгээний арга, харьцуулсан судалгааны арга, баримт бичгийн шинжилгээ болон кейс судалгааны аргыг хэрэглэсэн болно. АНУ–БНХАУ-ын стратегийн өрсөлдөөн, Орос–Украины мөргөлдөөн, ЗХА-ийн аюулгүй байдлын орчны өөрчлөлтийг жишээ болгон авч үзэв.

Орос–Украины 2022 онд эхэлсэн цэргийн тусгай ажиллагаа нь Европын 1945 оноос хойших аюулгүй байдлын архитектурт хамгийн том сорилтыг бий болгож, олон улсын геополитикийн орчныг үндсээр нь өөрчилсөн үйл явдал болов. Энэхүү мөргөлдөөн нь зөвхөн хоёр улсын хоорондын дайн бус, харин их гүрнүүдийн стратегийн өрсөлдөөний шинэ үе шат болж хувирсан. Оросын зүгээс НАТО-гийн тэлэлтийг үндэсний аюулгүй байдалд шууд заналхийлэл гэж үзсэн бол барууны орнууд Украины бүрэн эрхт байдал, олон улсын эрх зүйн зарчмыг хамгаалах шаардлагатай гэж үзсэн (Mearsheimer J. J., 2018). Мөргөлдөөний үр дүнд Европын аюулгүй байдлын бүтэц эрс өөрчлөгдөв. Францын Ерөнхийлөгч Эммануэль Макроны өмнө нь “тархины үхжилтэй” хэмээн тодорхойлж байсан НАТО байгууллага урьд өмнө байгаагүйгээр нэгдэн бэхжиж, Финланд болон Швед олон арван жилийн төвийг сахих бодлогоосоо татгалзан НАТО-д элссэн нь Европ дахь хүчний тэнцвэрт томоохон өөрчлөлт авчирсан үйл явдал юм (Wæver, 2003). Үүний зэрэгцээ Герман батлан хамгаалахын төсвөө үлэмж хэмжээгээр нэмэгдүүлж, Европын орнуудын дунд дахин зэвсэглэлтийн шинэ давлагаа эхэлсэн байна.

Барууны орнуудын эдийн засгийн өргөн хүрээтэй хориг арга хэмжээний хариуд ОХУ стратегийн чиглэлээ Ази руу эргүүлж, БНХАУ болон БНЭУ-тай эрчим хүч, худалдаа, санхүүгийн хамтын ажиллагаагаа өргөжүүлэв. Үүний үр дүнд ОХУ-БНХАУ-ын стратегийн хамтын ажиллагаа урьд өмнөхөөсөө илүү ойртож, Евроазийн эх газарт барууны нөлөөг сөрөх шинэ геополитикийн тэнхлэг бүрэлдэх нөхцөл бүрдэж байна (Kaplan R. D., 2012) (Mearsheimer J. J., 2018).

Ойрх Дорнодын бүс нутаг нь уламжлалт геополитикийн өрсөлдөөний төв хэвээр байгаа бөгөөд сүүлийн жилүүдэд АНУ-ын нөлөө харьцангуй буурснаар бүс нутгийн хүчний тэнцвэр шинэ хэлбэрт шилжиж байна. Израил–Хамасын мөргөлдөөн нь Израил болон Арабын орнуудын харилцааг хэвийн болгох зорилготой байсан Абрахамын хэлэлцээрийн хэрэгжилтэд хүндрэл учруулж, Палестины асуудлыг олон улсын улс төрийн анхаарлын төвд дахин авчирсан (Bremmer I. , 2022). Үүний зэрэгцээ Иран өөрийн нөлөөний хүрээг өргөжүүлэх зорилгоор Хезболла, Хуситууд болон бусад холбоотон бүлгээр дамжуулан бүс нутгийн стратегийн орон зайг тэлэхийг эрмэлзэж байна. Ялангуяа Улаан тэнгис болон Суэцийн сувгийн бүсэд

гарсан тогтворгүй байдал нь дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ болон эрчим хүчний аюулгүй байдалд шууд нөлөөлж байгааг харуулж байна (Tooze A. , 2021).

Ойрх Дорнод дахь өөр нэгэн чухал өөрчлөлт бол БНХАУ дипломат зуучлагчийн үүрэг гүйцэтгэж эхэлсэн явдал юм. Саудын Араб болон Ираны хоорондын олон жилийн дипломат зөрчлийг Бээжингийн оролцоотойгоор намжаасан нь Хятад зөвхөн эдийн засгийн төдийгүй дипломат нөлөөллийн төв болж байгааг харуулсан үйл явдал болсон (Bremmer I. , 2022).

Олон улсын харилцаанд “Глобал Өмнөд” гэх ойлголтын ач холбогдол сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байна. Энэхүү ойлголт нь хөгжлийн түвшин, колоничлолын түүх, эдийн засгийн бүтэц болон олон улсын дэг журамд эзлэх байр суурийн хувьд ижил төстэй улс орнуудыг хамардаг. Африк, Латин Америк, Өмнөд Ази болон Ойрх Дорнодын олон улс барууны болон барууны бус хүчний өрсөлдөөнд аль нэг талыг шууд баримтлахгүйгээр үндэсний ашиг сонирхолд тулгуурласан прагматик бодлого хэрэгжүүлж байна (Bremmer I. , 2022). Глобал Өмнөдийн улс орнуудын нөлөө өсөхөд БРИКС бүлгийн өргөжилт чухал түлхэц болов. Египет, Этиоп, Иран болон Арабын Нэгдсэн Эмират зэрэг улс тус бүлэгт нэгдсэнээр дэлхийн эдийн засаг, санхүүгийн засаглалын өнөөгийн тогтолцоонд шинэ сорилт бий болж байна. Эдгээр орон Олон улсын валютын сан, Дэлхийн банк зэрэг байгууллагын шинэчлэлийг шаардаж, олон туйлт дэлхийн дэг журмыг дэмжих хандлага нэмэгдэж байна (Tooze A. , 2021).

Орчин үеийн геополитикийн өрсөлдөөн зөвхөн цэрэг, дипломат харилцаагаар хязгаарлагдахгүйгээр геоэдийн засгийн шинжтэй болж хувирчээ. Геоэдийн засаг гэдэг нь эдийн засгийн хэрэгсэл, худалдаа, хөрөнгө оруулалт, санхүүгийн системийг стратегийн зорилгод ашиглахыг хэлдэг бөгөөд өнөөдөр их гүрнүүдийн өрсөлдөөний үндсэн хэрэгсэл болж байна (Kirshner, 2007). Үүний тод жишээ нь ОХУ-ын эсрэг хэрэгжүүлсэн санхүүгийн хориг арга хэмжээ юм. Америк болон түүний холбоотнууд Оросын төв банкны валютын нөөцийн тодорхой хэсгийг царцааж, хэд хэдэн банкныг SWIFT системээс хассан нь олон улсын санхүүгийн системийг геополитикийн хэрэгсэл болгон ашиглаж болохыг харуулсан үйл явдал болсон (Kirshner, 2007). Энэ нь олон улс оронд ам.долларын хэт хамаарлаас гарах, үндэсний валютаар худалдаа хийх, санхүүгийн эрсдэлийг төрөлжүүлэх талаар эрчимтэй хэлэлцэхэд хүргэсэн.

Эрчим хүчний шилжилт мөн геополитикийн шинэ өрсөлдөөнийг бий болгож байна. Өмнө нь газрын тос, байгалийн хийн нөөц стратегийн ач холбогдолтой байсан бол өнөөдөр лити, кобальт, никель, газрын ховор элемент зэрэг чухал ашигт малтмал нь ногоон шилжилтийн үндсэн нөөц болж байна. Эдгээр ашигт малтмалын нийлүүлэлтийн сүлжээнд БНХАУ давамгайл байр суурь эзэлж байгаа нь барууны орнуудын хувьд стратегийн эмзэг байдал үүсгэж байна (Kaplan R. D., 2012).

Технологийн салбар дахь өрсөлдөөн мөн нэмэгдсэн. Хагас дамжуулагчийн үйлдвэрлэл, хиймэл оюун, квант тооцоолол, кибер аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болсон бөгөөд технологийн давуу тал нь ирээдүйн хүчний харьцааг тодорхойлох хүчин зүйл болж байна. Үүний үр дүнд дэлхийн

технологийн экосистем барууны болон БНХАУ төвтэй хоёр өөр технологийн орон зайд хуваагдах эрсдэл улам бүр нэмэгдэж байна.

Зүүн хойд Ази дэлхийн геополитикийн төв болох нь

ЗХА нь өнөөдөр дэлхийн эдийн засгийн өсөлтийн гол хөдөлгүүр, технологийн инновацийн төв бөгөөд үүнтэй зэрэгцэн хамгийн өндөр түвшний стратегийн өрсөлдөөн өрнөж буй бүс нутаг болж байна. Бүс нутагт БНХАУ, ОХУ, АНУ зэрэг цөмийн зэвсэгтэй их гүрнүүдийн ашиг сонирхол огтлолцож, Япон улс болон БНСУ зэрэг өндөр хөгжилтэй орны аюулгүй байдлын асуудалтай нягт холбогддог онцлогтой. Иймээс ЗХА-ийн аюулгүй байдлын өөрчлөлт нь зөвхөн бүс нутгийн бус, дэлхийн тогтвортой байдалд шууд нөлөөлөх хүчин зүйл болж байна (Wæver, 2003).

Бүс нутгийн аюулгүй байдлыг тайлбарлахад Барри Бузан болон Оле Вæвер нарын боловсруулсан Бүс нутгийн аюулгүй байдлын комплексын онол (Regional Security Complex Theory) онцгой ач холбогдолтой. Энэхүү онолын дагуу газар зүйн хувьд ойр орших улсуудын аюулгүй байдлын асуудал харилцан нягт холбоотой байдаг бөгөөд нэг улсын аюулгүй байдлын өөрчлөлт нь хөрш орнуудын аюулгүй байдалд шууд нөлөөлдөг. ЗХА-д Тайванийн хоолой, Солонгосын хойг, Зүүн болон Өмнөд Хятадын тэнгисийн асуудал нь харилцан уялдаа бүхий нэгэн цогц аюулгүй байдлын орчныг бүрдүүлж байна (Wæver, 2003).

Дэлхийн хэмжээнд өрнөж буй хүчний шилжилт ЗХА-д хамгийн тод илэрч байна. АНУ-ын Номхон далайн бүс дэх олон арван жилийн стратегийн давамгайлал БНХАУ-ын эдийн засаг, цэргийн хүчин чадал өсөхийн хэрээр сорилттой тулгарч байгаа бөгөөд энэхүү өрсөлдөөн нь бүс нутгийн аюулгүй байдлын бүтцийг үндсээр нь өөрчилж байна (Friedberg A. L., 2011). ЗХА-ийн аюулгүй байдлын тогтолцоо уламжлалт хүчний тэнцвэрийн логигоор ажиллаж байна. БНХАУ-ын хүчин чадал өсөн нэмэгдэхийн хэрээр Япон улс болон БНСУ АНУ-тай тогтоосон холбоотны харилцаагаа улам гүнзгийрүүлж, стратегийн тэнцвэрийг хадгалах бодлого хэрэгжүүлж байна. Энэхүү үйл явц нь неореализмын онолд тодорхойлсон “External balancing” буюу гадаад тэнцвэржүүлэлтийн сонгодог жишээ юм (Waltz K. N., 1979).

Сорилт I: Гуравласан альянс ба БНХАУ-ыг тогтоон барих стратеги. Орчин үеийн ЗХА-ийн аюулгүй байдлын хамгийн том өөрчлөлтийн нэг нь АНУ-ын уламжлалт хоёр талт холбоотны систем шинэ шатанд гарч, АНУ–Япон улс–БНСУ-ын гуравласан хамтын ажиллагаа институцийн шинжтэй болж буй явдал юм. Кэмп Дэвидийн 2023 оны уулзалтын дараагаар гурван улсын батлан хамгаалах болон тагнуулын хамтын ажиллагаа мэдэгдэхүйц өргөжсөн бөгөөд энэ нь бүс нутгийн хүчний тэнцвэрт шинэ хүчин зүйл болж байна (Cha V. D., 2009).

Вашингтоны хувьд энэхүү хамтын ажиллагааны гол зорилго нь БНХАУ-ын өсөн нэмэгдэж буй нөлөөг тогтоон барих, Тайванийн хоолой болон Өмнөд Хятадын тэнгис дэх статус-квог хамгаалах явдал юм. Харин Бээжин үүнийг өөрийг нь

стратегийн бүслэлтэд оруулах оролдлого гэж үздэг бөгөөд бүс нутгийн цэрэгжилтийг улам эрчимжүүлэх шалтгаан болгож байна (Friedberg A. L., 2011).

Сорилт II: БНАСАУ-ын цөмийн стратеги ба ОХУ–БНАСАУ-ын ойртолт. Умард Солонгосын цөмийн хөтөлбөр нь бүс нутгийн тогтвортой байдалд хамгийн том заналхийлэл хэвээр байна. Пёньян сүүлийн жилүүдэд цөмийн статусаа үндсэн хуулиараа баталгаажуулж, урьдчилан сэргийлэх цөмийн цохилт өгөх боломжийг стратегийн баримт бичигтээ тусгасан нь бүс нутгийн аюулгүй байдлын орчныг улам эмзэг болгож байна (Cha V. D., 2009). Үүний зэрэгцээ Орос–Украины дайны дараагаар Москва болон Пёньяны харилцаа эрчимтэй ойртож байна. Хэрэв энэхүү хамтын ажиллагаа цэргийн технологи, пуужингийн систем, сансрын технологийн салбарт өргөжвөл ЗХА-ийн стратегийн тэнцвэрт урт хугацааны өөрчлөлт авчрах магадлалтай (Wæver, 2003).

Сорилт III: Япон улсын батлан хамгаалах бодлогын хувьсал. ЗХА-ийн аюулгүй байдлын бүтцийн хамгийн том өөрчлөлтийн нэг нь Япон улсын батлан хамгаалах бодлогын шинэчлэл юм. Дэлхийн II дайнаас хойш энхийг эрхэмлэсэн чиг шугам баримталж ирсэн Токио сүүлийн жилүүдэд үндэсний аюулгүй байдлын стратегиа шинэчилж, батлан хамгаалах төсвөө эрс нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн алсын тусгалтай цохилтын систем худалдан авах замаар өөрийн хамгаалах чадварыг өргөжүүлж байна (Glosserman B. , 2015). Энэхүү өөрчлөлт нь Япон улсын хувьд аюулгүй байдлын бодит хэрэгцээ боловч БНХАУ болон Солонгосын хойгийн орнуудад түүхэн дурсамжтай холбоотой болгоомжлол төрүүлж, бүс нутгийн үл итгэлцлийг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж байна (Glosserman B. , 2015).

Сорилт IV: Тайванийн хоолойн хямрал. Тайванийн асуудал нь ЗХА-ийн аюулгүй байдлын хамгийн эмзэг асуудал болж байна. Тайванийн хоолойд томоохон хэмжээний мөргөлдөөн гарсан тохиолдолд бүс нутгийн бүх гол тоглогчид шууд болон шууд бусаар татагдан оролцох эрсдэлтэй (Friedberg A. L., 2011). Тайвань нь зөвхөн геостратегийн ач холбогдолтой бус, мөн дэлхийн хагас дамжуулагчийн үйлдвэрлэлийн төв учир геоэдийн засгийн хувьд онцгой чухал байр суурь эзэлдэг. Тайванийн хоолой дахь тогтворгүй байдал нь дэлхийн нийлүүлэлтийн сүлжээ, технологийн үйлдвэрлэл, худалдааны урсгалд асар их нөлөө үзүүлэх боломжтой бөгөөд энэ нь ЗХА-ийн орнуудын эдийн засагт шууд эрсдэл учруулна (Pempel T. J., 2005).

Монгол Улсад үзүүлэх нөлөө, боломж

ЗХА-д өрнөж буй геополитикийн туйлшрал, их гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогод шууд нөлөөлж байна. ОХУ болон БНХАУ-ын стратегийн хамтын ажиллагаа гүнзгийрч, нөгөө талд АНУ тэргүүтэй барууны орнуудын хамтын ажиллагаа бэхжиж байгаа

нөхцөлд Монгол Улс хоёр том хүчний ашиг сонирхлын огтлолцолд орших геостратегийн эмзэг байрлалтай хэвээр байна. Ийм нөхцөлд тусгаар тогтнол, стратегийн автономит байдлыг хадгалах нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үндсэн зорилт болж байна (Wæver, 2003). Гэсэн хэдий ч энэхүү геополитикийн өрсөлдөөн нь Монгол Улсад тодорхой боломжийг мөн бий болгож байна. Монгол Улс бүс нутгийн улс орнуудын хооронд итгэлцлийг дэмжих, албан бус яриа хэлэлцээний талбар болох дипломат давуу талаа ашиглах боломжтой. Ялангуяа “Улаанбаатарын яриа хэлэлцээ” санаачилга нь бүс нутгийн аюулгүй байдлын асуудлыг хэлэлцдэг цөөн сувгийн нэг болж, Монгол Улсын олон улсын нэр хүндийг нэмэгдүүлж байна (Lhagva, 2022).

Орчин үеийн Евроазийн геополитикийн өөрчлөлт, АНУ–БНХАУ-ын стратегийн өрсөлдөөн, Орос–Украины дайны дараах олон улсын орчны өөрчлөлт нь Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлогын ач холбогдлыг улам нэмэгдүүлж байна. Энэхүү бодлого нь Монгол Улс хоёр хөршөөс гадна АНУ, Япон улс, БНСУ, БНЭУ болон Европын Холбооны орнуудтай улс төр, эдийн засаг, аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлэх замаар гадаад бодлогын тэнцвэрийг хангах зорилготой.

Олон улсын харилцааны онолын үүднээс авч үзвэл Монгол Улсын хэрэгжүүлж буй энэхүү бодлого нь Куйкийн тодорхойлсон “hedging strategy” буюу их гүрнүүдийн өрсөлдөөний нөхцөлд аль нэг талд бүрэн дагаар орохгүйгээр эрсдэлийг бууруулж, боломжийг нэмэгдүүлэх стратегитай төстэй байна (Kuik C.-C., 2008).

Монгол Улсын экспортын дийлэнх хэсэг БНХАУ-ын зах зээлээс хамааралтай бөгөөд эрчим хүч, шатахууны нийлүүлэлтийн гол эх үүсвэр нь ОХУ хэвээр байна. Ийм өндөр төвлөрсөн бүтэц нь геополитикийн хурцадмал нөхцөлд үндэсний эдийн засгийн эмзэг байдлыг нэмэгдүүлдэг. Тиймээс гуравдагч хөршүүдтэй хийх худалдаа, хөрөнгө оруулалт, технологийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нь эдийн засгийн аюулгүй байдлын чухал зорилт болж байна (Kirshner, 2007).

Ногоон шилжилт болон дэлхийн технологийн өрсөлдөөний эрчимжилт нь Монгол Улсын ашигт малтмалын стратегийн ач холбогдлыг нэмэгдүүлж байна. Газрын ховор элемент, зэс, молибден, литийн боломжит нөөц нь Монгол Улсыг дэлхийн нийлүүлэлтийн шинэ сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлж байна. Ийм нөхцөлд ашигт малтмалын салбарыг үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын хэрэгсэл болгон ашиглах шаардлага бий болж байна.

АНУ, Япон улс, БНСУ, Европын Холбооны орнуудтай стратегийн түншлэлийн хүрээнд ашигт малтмалын хамтарсан төслүүд хэрэгжүүлэх нь Монгол Улсын геоэдийн засгийн үр ашгийн нэмэгдүүлэх ач холбогдолтой.

Олон улсын харилцааны өнөөгийн нөхцөлд стратегийн автономит байдал гэдэг нь зөвхөн цэрэг-улс төрийн асуудал биш бөгөөд эдийн засаг, технологи, кибер аюулгүй байдал, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдалтай шууд

холбоотой ойлголт болсон байна (Kuik С.-С. , 2008). Иймээс Монгол Улс НҮБ болон олон улсын байгууллагуудын хүрээнд олон улсын эрх зүй, НҮБ-ын дүрэмд тулгуурласан төвийг сахисан, прагматик байр суурийг хадгалах нь үндэсний ашиг сонирхолд нийцнэ. Энэ нь том гүрнүүдийн өрсөлдөөний нөхцөлд тусгаар тогтнол, аюулгүй байдлыг хамгаалах хамгийн бодитой арга замын нэг юм.

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэх шаардлага

ЗХА-ийн геополитикийн өөрчлөлт, их гүрнүүдийн стратегийн өрсөлдөөн, геоэдийн засгийн дарамт, кибер болон мэдээллийн орчны шинэ сорилтууд нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын тогтолцоог шинэ нөхцөлд дахин үнэлэх шаардлагыг бий болгож байна. 2010 онд батлагдсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь тухайн үеийн олон улсын орчинд нийцэж байсан боловч өнөөгийн “Тэгш бус олон тулгуурт систем” (Asymmetric Multipolarity)-ийн нөхцөлд шинэчлэн боловсруулах шаардлагатай болжээ.

Гибрид заналхийллийг эрх зүйн түвшинд тодорхойлох нь. Орчин үеийн аюулгүй байдлын сорилтууд зөвхөн уламжлалт цэргийн заналхийллээр хязгаарлагдахгүй болсон. Кибер халдлага, мэдээллийн нөлөөллийн ажиллагаа, эдийн засгийн шахалт, нийлүүлэлтийн сүлжээний доголдол зэрэг хүчин зүйл нэгэн зэрэг хэрэгждэг гибрид заналхийллийн шинжтэй болж байна. Иймээс Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд “гибрид аюулгүй байдал” гэсэн шинэ бүлгийг тусган, төрийн байгууллагуудын уялдаа холбоог эрх зүйн түвшинд тодорхой болгох шаардлагатай байна.

Стратегийн төрөлжилтийг хуульчлах шаардлага. Монгол Улсын “Гуравдагч хөрш”-ийн бодлого нь гадаад бодлогын амжилттай механизм болсон боловч практикт улс төрийн тунхаглалын шинж чанартай хэвээр байна. Иймээс стратегийн түншлэлүүдийг эдийн засаг, технологи, боловсрол, чухал ашигт малтмалын урт хугацааны хамтын ажиллагааны гэрээгээр баталгаажуулж, үндэсний аюулгүй байдлын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгон хуульчлах шаардлагатай.

Санхүүгийн аюулгүй байдлын эрх зүйн механизм. Санхүүгийн хориг арга хэмжээ нь сүүлийн жилүүдэд олон улсын харилцааны гол хэрэгсэл болж хувирсан. ОХУ-ын эсрэг хэрэгжүүлсэн хориг арга хэмжээнүүд нь олон улсын төлбөр тооцооны системийн эмзэг байдлыг тодорхой харуулсан. Монгол Улсын хувьд хоёрдогч хоригийн эрсдэлийг бууруулах, төлбөр тооцооны олон сувгийг бий болгох, үндэсний санхүүгийн тогтвортой байдлыг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна.

Дижитал тусгаар тогтнол ба кибер аюулгүй байдал. Технологийн өрсөлдөөн эрчимжиж буй өнөөгийн нөхцөлд дижитал тусгаар тогтнол нь үндэсний аюулгүй байдлын салшгүй хэсэг болж байна. Монгол Улс төрийн мэдээллийн систем, стратегийн ач холбогдолтой дэд бүтцийн өгөгдлийн хамгаалалт, үндэсний

дата төвүүдийн хөгжлийг эрх зүйн бодлогоор дэмжих шаардлагатай. Үүнтэй холбоотойгоор Кибер аюулгүй байдлын тухай хуулийн хэрэгжилтийг улам боловсронгуй болгож, үндэсний хэмжээний кибер тэсвэрлэх чадварыг бэхжүүлэх шаардлагатай.

Дүгнэлт

XXI зууны геополитикийн өөрчлөлт нь дэлхийн хүчний бүтэц, эдийн засаг, технологи, аюулгүй байдлын ойлголтын чанарын өөрчлөлт бий болж буйг харуулж байна. Хүйтэн дайны дараах нэг тулгуурт дэлхийн дэг журам аажмаар сулран, АНУ, БНХАУ тэргүүтэй их гүрнүүдийн өрсөлдөөн давамгайлсан шинэ хэлбэрийн олон тулгуурт тогтолцоо бүрэлдэж байна. Энэхүү өөрчлөлт хамгийн тод илэрч буй бүс нутаг бол Зүүн хойд Ази юм. Тайванийн хоолойн асуудал, Солонгосын хойгийн цөмийн асуудал, АНУ–Япон улс–БНСУ-ын хамтын ажиллагаа болон БНХАУ–ОХУ–БНАСАУ-ын стратегийн ойртолт нь бүс нутгийн аюулгүй байдлыг урьд өмнөхөөс илүү төвөгтэй болгож байна.

Монгол Улсын хувьд энэхүү орчин нь эрсдэл болон боломжийг зэрэгцүүлэн бий болгож байна. Нэг талаас, хоёр хөрш болон их гүрнүүдийн өрсөлдөөний дунд орших геостратегийн эмзэг байдал хадгалагдаж байгаа бол нөгөө талаас, дипломат зуучлал, стратегийн автономит байдал, гуравдагч хөршийн бодлого, чухал ашигт малтмалын дипломат ажиллагаагаар дамжуулан үндэсний ашиг сонирхлоо хамгаалах боломж өргөжиж байна.

Иймээс Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын бодлого нь уламжлалт цэрэг-улс төрийн аюулгүй байдлаас гадна эдийн засаг, технологи, кибер орон зай, нийлүүлэлтийн сүлжээний тогтвортой байдлыг хамарсан цогц ойлголтод суурилах шаардлагатай байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалыг шинэчлэх, стратегийн төрөлжилтийг бэхжүүлэх, дижитал тусгаар тогтнолыг хамгаалах, олон талт дипломат ажиллагааг тууштай хэрэгжүүлэх нь Монгол Улсын тусгаар тогтнол, стратегийн автономит байдлыг хадгалах үндсэн нөхцөл болох юм.

Эх сурвалжийн жагсаалт

Allison, G. (2017). *Destined for war: Can America and China escape Thucydides's trap?*. Houghton Mifflin Harcourt.

Allison, G. T. (2017). *Destined for War? The National Interest*, The National Interest, (149).

Bremmer, I. (2022). *The Power of Crisis: How Three Threats – and Our Response – Will Change the World*. Simon & Schuster.

Buzan, B., & Wæver, O. (2003). *Regions and powers: The structure of international security*. Cambridge University Press.

- Cha, V. D. (2016). *Powerplay: The origins of the American alliance system in Asia*. Princeton University Press.
- Friedberg, A. L. (2011). *A contest for supremacy: China, America, and the struggle for mastery in Asia*. W. W. Norton & Company.
- Fukuyama, F. (1992). *The end of history and the last man*. Free Press.
- Glosserman, B. (2015). *The Japan-South Korea Identity Clash: East Asian Security and the United States*. Columbia University Press.
- Glosserman, B., & Snyder, S. (2015). *The Japan–South Korea identity clash: East Asian security and the United States*. Columbia University Press.
- Johnston, A. I. (2003). Is China a Status Quo Power? *International Security*, 5-56.
- Kaplan, R. D. (2012). *The Revenge Of Geography What The Map Tells Us About Coming Conflicts And The Battle Against Fate*. Random House Publishing Group, 2012.
- Kirshner, J. (2007). *Appeasing the gods of Washington: Financial power and international security*. Princeton University Press.
- Kuik, C.-C. (2008). The Essence of Hedging: Malaysia and Singapore's Response to a Rising China. *Contemporary Southeast Asia: A Journal of International and Strategic Affairs*, 159-185.
- Lhagvaa, B. (2022). Mongolia's strategic autonomy and the UB dialogue. 14(2), 45–62. *Journal of International Studies*, 45–62.
- Mackinder, H. J. (1904). The geographical pivot of history. . *The Geographical Journal*, 23(4), 421–437.
- Mearsheimer, J. J. (2018). *The great delusion: Liberal dreams and international realities*. Yale University Press.
- Pempel, T. J. (2005). *Remapping East Asia: The Construction of a Region*. Cornell University Press.
- Spykman, N. J. (1944). *The geography of the peace*. Harcourt. Brace and Company.
- Tooze, A. (2021). *Shutdown: How Covid Shook the World's Economy*. Penguin Books Limited.
- Wæver, B. B. (2003). *Regions and Powers*. Cambridge University Press.
- Waltz, K. N. (1979). *Theory of international politics*. Addison-Wesley.

Geopolitical changes: Security challenges in Northeast Asia and Mongolia's perspective

Boldbaatar Zagdsuren

Doctor (Sc.D), Professor, Research Fellow, z.boldbaatar.postgrad@gmail.com
Mongolia, Ulaanbaatar, Defence Research Institute of Mongolia

Abstract

This article examines the changes in the international system and their impact on the security environment of Northeast Asia and Mongolia. The study analyzes the transition from the post-Cold War unipolar system to an asymmetric multipolar order characterized by intensifying great power competition. Drawing on the theoretical frameworks of neorealism, offensive realism, geopolitical theory, and Regional Security Complex Theory (RSCT), the study examines key geopolitical developments, including U.S.-China strategic competition, the consequences of the Russia-Ukraine war, the evolving security landscape in Northeast Asia, and the growing influence of the Global South.

Within this shifting strategic environment, Mongolia's foreign policy and security challenges are assessed through the lens of strategic autonomy and the Third Neighbor policy. The findings suggest that in order to preserve its sovereignty and national security amid intensifying great power competition, Mongolia must strengthen its multi-pillar, balanced cooperation policy; diversify its economic and technological partnerships; enhance its cyber and economic resilience; and develop institutionalized mechanisms for regional dialogue.

The article concludes that under the current conditions of an emerging asymmetric multipolar order, Mongolia must update and develop its National Security Concept to comprehensively address both traditional and non-traditional security dimensions, encompassing geopolitical, economic, technological, and cyber challenges.

Keywords: *Asymmetric multipolar order; great power competition; geoeconomics; Third Neighbor policy; hybrid threats; digital sovereignty*

Received: June 15, 2026 | Accepted: June 29, 2026 | Published online: July 07, 2026



© The Author(s) 2026

<https://creativecommons.org/licenses/by/4.0/>.